



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 24 -ны өдөр

Дугаар А/64

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 04 сарын 13-ны өдрийн А/223 тоот захирамжийн 2-р зорилтын 16 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагын ажилчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж буй 40-өөс дээш насны албан хаагчдын дунд хавдарын маркерын шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Шаардлагатай төсөв болох 10.000.000 /Арван сая төгрөг/-г нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ

“Эмч” хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн ажилтнуудыг
хавдарын маркерийн шинжилгээнд хамруулах
үйл ажиллагааны удирдамж

Үндэслэл:

Монгол улсад хорт хавдрын шинэ өвчлөлийн оношлогдсон үе шатыг сүүлийн 10 жилийн дунджаар харвал 10 хүний 2 нь эрт үедээ, 8 нь хожуу үедээ оношлуулж байна. 2010-2020 оны байдлаар хорт хавдар оношлогдсон хүн амын 77% нь өвчнийхөө III, IV үе шатанд оношлогдож, хорт хавдрын шалтгааны улмаас нас барсан нийт хүн амын 73 хувь нь анх оношлогдсоноосоо хойш 1 жил хүртэлх хугацаанд амьдарсан байна. Хорт хавдарыг эрт үед нь оношилсоноор хорт хавдарын өвчлөлийн 1/3- ийг нь эмчлэх боломжтой. Хорт хавдарын оношилгоонд эмнэлзүйн үзлэг лабораторийн болон дүрс оношилгооны шинжилгээ эд, эс зүйн шинжилгээ зэрэг олон төрлийн аргыг ашигладаг. Орхон аймгийн төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудын 40-өөс дээш насны албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж лабораторийн шинжилгээний аргаар хавдарын маркерийн шинжилгээнд оруулах шаардлагатай байна. Эрүүл мэндийн байгууллагуудын ажилчид халдвартай үйлчлүүлэгчтэй болон цус цусан бүтээгдэхүүн, цацраг идэвхит орчин, олон цагаар мэс ажилбар хийх зэрэг хүнд нөхцөлд олон цагаар эрсдэлтэй орчинд ажилладаг билээ.

Зорилго: Эрүүл мэндийн ажилтны эрүүл мэндийг дэмжих хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны 04 сарын 13-ны өдрийн ““Эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны арга хэмжээний төлөвлөгөө төсвийг батлах тухай” А/223 тоот захирамжийн 2-р зорилтын 16 дахь заалтыг хэрэгжүүлэх

Зорилт-1.Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж буй ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах

Зорилт-2.Урьдчилан сэргийлэх үзлэгийн дүнг нэгтгэж, дүн шинжилгээ хийх, мэдээлэх, тайлагнах

Зорилт-3. Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж буй 40-өөс дээш насны албан хаагчдын дунд 5 төрлийн хавдарын маркераас ямар шинжилгээнд хамрагдах талаар судалгаа авах

Зорилт-4. Судалгаанд үндэслэн албан хаагчдыг шинжилгээнд хамруулах

Зорилт-5.Шинжилгээний нэгдсэн дүнг аймгийн ЗДТГ-ын НБХ-т танилцуулах

Хамрах хүрээ:

-Эрүүл мэндийн газар

-Бүсийн оношилгоо эмчилгээний төв

-Өрхийн эрүүл мэндийн төвүүд

-Жаргалант сумын эрүүл мэндийн төв

- Хамтран хэрэгжүүлэх байгууллага: ЗДТГ, Эрүүл мэндийн газар, “Оношлаб” ХХК-ны Онош лаборатори